



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/113

Арвайхээр

Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд  
зарим хязгаарлалтыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 08-ны 07 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт (Ковид-19) цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн төв Арвайхээр сумаас эрүүл мэндийн шалтгаантай, буяны үйл ажиллагаа, хүнс, шатахуун, түлээ нүүрс, малын тэжээлийн тээврээс бусад гарах болон орох авто тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 15-ны 06.00 цаг хүртэл хязгаарласугай.


2. Арвайхээр сумын өрөнхий боловсролын сургуулиудын танхимиын давтлага, төв барааны зах, худалдааны төвүүд, такси үйлчилгээ, спорт заал, фитнесс, усан басейн, үсчин, гоо сайхан, гандан хийд, гуанз ресторан зэргийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 15-ны 06.00 цаг хүртэл хориглосугай.

3. Коронавируст халдварт (Ковид-19) цар тахлын батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтлуудыг шуурхай тогтоож, тандалт шинжилгээнд хамруулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймаг дахь Тагнуулын хэлтэс (хурандаа Ж.Уламбаяр)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн нэгдүгээр заалтыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Автотээврийн төв (Д.Амартувшин), Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН



011100252